

ШАТАН ОРЧМЫН ШУВУУНЫ ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ БА ОНЦЛОГ

Ганболдын Онолрагчаа*, Мөнхбаярын Мөнхбаатар, Пүрвээгийн Эрдэнэтүшиг,
Хүдэрчулууны Отгонцэцэг

Монгол улсын боловсролын их сургууль, Математик-Байгалийн ухааны сургуулийн Биологийн тэнхим
Харилцах хаяг: f.naumann13@gmail.com*

хураангуй. Бид сүүлийн 10 орчим жилийн хугацаанд жил бүр хийгдэж ирсэн оюутны зуны хээрийн дадлагын ажлын явцдаа Төв аймгийн Батсүмбэр сумын Шатангийн ам, Өлгийн амын холимог болон хусан ой, Өлгий болон Шатан голын хөндийн ус намгархаг газарт нийт 15 баг, 36 овог, 97 төрөлд хамаарах 149 зүйл шувууг ажиглан бүртгэлээ. Эдгээрээс зүйл нь Монгол орны болон бүс нутгийн хэмжээнд ховор болон ховордож байгаа 11 зүйл шувууд байна. Мөн CITES-ийн болон CMS-ийн хавсралтанд орсон нийт 35 зүйл шувуу бүртгэгдлээ.

Түлхүүр үг: зүйлийн бүрдэл Шатан, Төв аймаг

Тоодог 1:36-39, 2014

Оршил

Монгол орны хэмжээнд тодорхой газар нутгийн шувуудын зүйлийн бүрдлийг бүрэн тодорхойлох шаардлага одоог хүртэл байсаар байна. Ялангуяа уул уурхай, дэд бүтэц, газар тариалангийн хөгжилтэй уялдан газрын харилцааны асуудал ихэд өөрчлөгдөж байгаатай уялдаад тодорхой газар нутагт байгаа биологийн олон янз байдлыг тодруулах, бүртгэх, баримтжуулах асуудал сүүлийн үед илүү ач холбогдолтой болж байна.

МУБИС-ийн Математик Байгалийн Ухааны Сургуулийн Биологи, Газарзүйн ангийн оюутнууд зуны хээрийн дадлагыг сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Төв аймгийн Батсүмбэр сумын Шатанд хийж гүйцэтгэж байгаа билээ. Хээрийн дадлагын хугацаанд багш, оюутнууд энэ нутгийн шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгойд жил бүр тогтмол ажиглалт явуулдаг бөгөөд өнгөрсөн хугацаанд цугларсан мэдээ материал дээр үндэслэн энэ нутгийн шувуудын зүйлийн бүрдэл, онцлогийг тодруулахыг зорив.

Шатан орчим нь Төв аймгийн Батсүмбэр сумын Баянбуурал багийн нутагт Улаанбаатар хотоос хойш 120 км зайд оршдог. Энэ район нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Орхон-Сэлэнгийн сав газрын хөмбөн-цулдам уул, хотгорын мужийн Орхон-Туулын сав газрын дэд мужид хамаарна. Тус районы хамгийн өндөр цэг хээрийн суурингын баруун талд

орших 1628 м өндөртэй Цогт-Өндөр уул, нам цэг нь Шатангийн голын хараа гол руу цутгаж буй адагт 1200 м өндөртэй байна. Нутгийн ихэнх хэсгийн уулын араар холимог болон хусан ой, харин Хараа, Өлгий, Шатан голын дагуу татмын нуга, голын хөндийтэй. Уул хоорондын хөндийд алаг өвс, хялганат болон уулалж алаг өвст ургамлын хэв шинж холилдон зонхилно. Бидний судалгааны талбай нь Хан Хэнтийн дархан газрын орчны бүсэд багтах учир тэнд ховор элдэв зүйл хөхтөн, шувууд тархан амьдрах нь элбэг байдаг (Зураг 1). Энэ нутагт газар тариалан төдийлөн эрхэлдэггүй ба өрхийн хэмжээний жижиг газар тариалан эрхэлж, төмс, байцаа, лууван гэх мэт хүнсний ногоо ихэвчилэн тариална, харин уул уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртөөгүй ба Орос Монголыг холбосон төмөр замын засварын үйл ажиллагаанд зориулж уулын хормой, бэлээс шороо, хайрга олборлосон үл мөрүүд



Зураг 1. Шатангийн амны ерөнхий байдал

мөн төмөр замын гүүрийг шинэчлэх явцад шатан голын хараа гол руу цутгах цутгалын голдирлыг өөрчлөн, хуучин урсацаас гүехэн, загас жараахай Шатан голруу орох зэргийг хязгаарласан зэрэг хүний үйл ажиллагааны нөлөө үлдэж хоцорсон.

Арга зүй

Бид 2010-2014 оны хооронд судалгааг жил бүрийн 6-р сарын 1-17-ны хооронд нийт 68 км² орчим нутаг дэвсгэрт хэсэгчлэн хийж гүйцэтгэсэн болно. Бидний хээрийн судалгааны хугацаа болох 6-р сарын эхний хагас нь шувуудын үржлийн болон жилийн хамгийн идэвхитэй үе байдаг ба бидэнд илүү олон зүйл шувуу ажиглах боломж байв. Мөн нэмэлт мэдээлэл болгон өмнөх судлаачдын мэдээг ашигласан болно.

Хээрийн судалгаанд түгээмэл ашиглагддаг ажиглах, бүртгэх, маршрутын аргыг хэрэглэн дээж материал цуглуулсан. Хээрийн ажиглалтанд бид хоёр нүдний дуран, телескоп, GPS, хонгил нүхний доторхийг шалгадаг уян дуран, шувууны өнгөт зураг бүхий гарын авлага, зургийн аппарат хэрэглэсэн.



Зураг 2. Шатан орчмын шувуудын амьдрах орчин.

- а) голын хөндий, б) хусан ой, в) уулын энгэр, хадархаг орчин, г) Шатан өртөө орчмын суурин газар

Хээрийн ажиглалтыг шувуудын амьдрах орчин тус бүрээр явуулж таарсан шувуудыг зүйлээр тодорхойлж, тоо толгойн тойм, оршин амьдрах хэлбэр зэргийг бүртгэн тэмдэглэж байсан. Судалгааны явцад зарим нуугдмал амьдралтай шувуудын ул мөр, ялгадас зэргээр таниж тодорхойлсон ба ихэнх зүйлийг гэрэл зургаар баталгаажуулсан. Мөн өөр хоорондоо

ялгаа бүхий амьдрах орчин бүрээс тухайн орчинг бүрэн төлөөлөх шувуудыг ажиглан тэмдэглэж дээж материалаа цуглуулсан. Монгол орны шувууны улаан дансны үнэлгээг ашиглан бүртгэгдсэн шувуудын зүйл бүрийн Монгол орны болон бүс нутгийн хэмжээн дэхь ховордлын үнэлгээ, олон улсын гэрээ конвенцийн хавсралтад хэрхэн орсон байдлыг тодруулав (Гомбобаатар ба бусад 2009).


Үр дүн ба дүгнэлт

Бид Шатан орчимд нийт 15 баг, 36 овог, 97 төрөлд хамаарах 149 зүйл шувууг бүртгэсэн. Бидний бүртгэн тэмдэглэсэн шувуудын 54% ийг боршувуутан баг, 10%-ийг шонхортоны баг, 9%-ийг хиазтаны багийн, 6%-ийг галуу хэлбэртэний багийн төлөөлөгчид эзэлсэн юм (Зураг 3).

Шувуудыг амьдрах орчин тус бүрээр ангилахад ой бүхий газарт 70 зүйл, хадархаг уулсад 18 зүйл, гол, нуга бүхий газарт 45 зүйл, суурин газарт 16 зүйл шувуудыг ажиглан тэмдэглэсэн байна (Зураг 3). Шатан орчмын шувуудад хамгийн чухал амьдрах орчин нь ой мод, уул хад болно. Уул хоорондын хөндийд урт сүүлт зурамны бүл нүх маш их байх ба тэдгээрийн орхигдсон нүхэнд хөх цэгцгий, бүжимч чогчиго гэх мэт шувууд ихээр үүрлэх ба бид тухайн орчимд 300м² талбайд тохиолдсон бүх нүхийг бөглөн эзэн амьтдыг тодорхойлж үзэхэд нийт нүхний 30 орчим хувьд нь ямар нэгэн шувууны ул мөр үлдсэн байсан. Хууль бус ой модны олборлолтын ул мөр тухайн нутагт түгээмэл ажиглагдах ба уулын бэлээс уулын орой хэсэгт хүрсэн техникийн жим гарсан байх ба огтлогдсон нойтон модны ёзоор ихээр тааралддаг. Хэдэн арван жилийн өмнөх түймрийн улмаас шатсан шинэсэн ойны үлдэгдэл болох ганц нэг том шинэс, мөн шинээр ургаж буй болсон шигүү хусан ойн түүний захаар ургах нялх шинэс модон төгөл зэргээр тухайн орчмын ойг түрсэлж болно. Төмөр зам даган бий болсон суурин газрууд тухайн орчимд нилээдгүй бий тухайлбал: Шатан зөрлөг, Өлгий өртөө, Өлгий гол даган үүссэн айлын төвлөрөл гэх мэт.

Шатан орчимд олон улсад болон бүс нутгийн үнэлгээгээр устаж болзошгүй ангилалд 1, эмзэг ангилалд 5 зүйл, ховордож болзошгүй

ангилалд 5, анхааралд өртөхөөргүй ангилалд (LC) 144 зүйл шувуу, CITES-ийн хавсралтанд багтсан 20, CMS-ийн хавсралтанд 15 зүйл тус тус орсон байна.



Зураг 3. Шатан орчмын шувуудын зүйлийн бүрдэл (багаар)

Ажиглалтын хугацаанд түгээмэл тохиолдож байсан зүйлүүдийг дурьдвал, алагтуу хэрээ (*Corvus dauricus*), хар хэрээ (*Corvus corone*), улаан хушуут (*Pyrrhocorax pyrrhocorax*), алаг шаазгай (*Pica pica*), сохор элээ (*Milvus migrans*), хөх цэгцгий (*Motacilla alba*), их хөхбүх (*Parus major*), хондон ангир 3-4 үржлийн хос (*Tadorna ferruginea*), хээрийн боршувуу (*Passer montanus*), хөхвөр тагтаа (*Columbia livia*), нарийн хиазат (*Charadrius dubius*), эгэлхайргын хөгчүү (*Actitis hypoleucos*), хөхөө (*Cuculus sp*), цагааншанаат хөмрөг (*Emeriza leucocephalos*) гэх мэт шувууд түгээмэл тохиолдож байв.

Хараа гол руу түрэн орсон бэсрэг толгодын хадны завсарт зээрд шонхорын бүл үүрлэн үрждэг болохыг бид 2012 онд олж тухайн бүлийг 2 жилийн турш ажиглан бүртгэсэн. Тухайн орчимд зээрд шонхорын 3-4 бүл буюу 6-8 нас бие гүйцсэн шувуу байсан. 2014 оны байдлаар 1-р үүрэнд 4 өндөг, 2-р үүрэнд 4 өндөг, 3-р үүрэнд 5 өндөг байсан. Мөн бид шинэсэн дээр үүрлэсэн нөмрөг тасын үүрийг олсон ба уг үүрнээс 2013, 2014 онуудад дараалан ангаахай нь амжилттай ниссэн болно. Мөн Хараа, Өлгий голын хөндийд зэрлэг нугасны 2 үүр (тус бүр 8 өндөг), умардын хавтгаалжийн 1 бүл, нарийн хиазатын 1 үүр (4 цоохор өндөг), төмөр замын гүүрэн дор улаанхушуутын 1 үүр (4 ангаахай), модны хонгилд хөхбүхын, мэрэгчийн хуучин нүхэнд бүжимч чогчигоны үүр тэмдэглэгдсэн. Агнуурын ач холбогдол бүхий шувууд болох

дагуур ятуу, нургын сойр шинэсэн болон холимог ойн захаар таарна.

Ойн шувуудын амьдралд онц аюул учруулдаг хүчин зүйл бол ойн түймэр юм. Бидний жил бүрийн ажиглалтаар Шатан орчимд гал түймэрт автсан ул мөр ихээр тохиолддог нь ойн шувуудад аюул занал учруулдаг болох нь тодорхой. 2003 оны хээрийн дадлагын үеэр буюу 6 сарын эхний хагаст дадлагын суурин орчимд ойн түймэр ихээр дэгдэж тухайн үеийн багш оюутнууд хээрийн дадлагаас бууж байсан тохиолдол гарч байжээ. Мөн тухайн нутгийн малчин ард тохиолдолоор эргийн шувуудын үүрлэх орчин болох голын нуга намаг бүхий газраар нутаглаж улмаар мал сүрэг нь ихээр бэлчээрлэн, талхладаг нь тэнд үүрлэдэг умардын хавтгаалж, элдэв зүйл хөгчүү зэрэг шувуудын өндөг, ангаахайд тодорхой хэмжээний аюул учруулж байна.

Цаашид энэ нутгийн шувуудын экологи, биологи улмаар хамгааллын талын судалгааг илүү нарийвчлан гүйцэтгэж, шувууны тухай мэдээлэл бүхий гарын авлага гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Шатан орчим нь байгаль орчны ямар нэгэн доройтолд өртөөгүй, унаган байгалиа харьцангуй хадгалан үлдсэн, гол горхи, нуга намаг, уул хад, ой мод зэрэг манай орны шувуудын үндсэн амьдрах орчингууд бүрэлдсэн учир шувуудын хувьд ихээхэн ач холбогдолтой чухал газар нутаг гэж үзэж байна.

Талархал

Хээрийн судалгаа явуулах нөхцөл боломж бололцоогоор хангаж өгсөн МУБИС болон салбар сургууль болох Байгалийн Ухааны Сургуулийн захиргаа мөн үнэтэй мэдээ мэдээллээ харамгүй солилцож байдаг эрдэмтэн багш нар, үе үеийн судлаач оюутан нартаа гүн талархал илэрхийлье.

Ашигласан бүтээл

- Brazil, M. 2009. Birds of East Asia. Christopher Helm.
 Gombobaatar, S., E. M. Monks, R. Seidler, D. Sumiya, N. Tseveenmyadag, S. Bayarkhuu, J. E. M. Baillie, S. Boldbaatar, and C. Uuganbayar, editors. 2011. Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia, and Mongolian Ornithological Society.

Болдбаатар, Ш. 2013. Монгол орны шувууны фото лавлах, 2-р хэвлэл Улаанбаатар.

Пунсалпаамуу, Г., Ш. Дариймаа, М. Мөнхбаатар, Ж. Ариунболд, Ц. Сэр-Од, Г. Онолрагчаа. 2012. Шатан орчмын экологийн судалгааны тайлан. МУБИС, Байгалийн ухааны сургууль, Улаанбаатар.

Цэвээнмядаг, Н., А. Болд, Ш. Болдбаатар, Г. Майнжаргал. 2005. Хэнтийн уулархаг мужийн шувуу лавлах бичиг, Улаанбаатар.